



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 367

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.6, 46.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Парламентын судалгаа шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (Ц.Цогзолмаа)-д даалгасугай.

3.Эрдэм шинжилгээний сэтгүүлийг хэвлүүлэх хөрөнгө, зардлыг Улсын Их Хурлын Тамгын газрын жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү, хангамж үйлчилгээний хэлтэс (Б.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Л.ӨЛЗИЙСАЙХАН

2022001113

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 367 захирамжийн хавсралт

**“ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ”  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ  
ЭРХЛЭН ГАРГАХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Монгол Улсын Их Хурлын Тамгын газар (цаашид “Тамгын газар” гэх)-ын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (цаашид “Хүрээлэн” гэх)-ээс “Парламентын судалгаа шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл (цаашид “Сэтгүүл” гэх)-ийг эрхлэн гаргахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сэтгүүлийн зорилго нь Улсын Их Хурлын хэлэлцэн баталж буй хууль тогтоомжийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, судалгаа шинжилгээ, баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

1.3.Сэтгүүлийг үүсгэн байгуулагч нь Улсын Их Хурлын Тамгын газар байх бөгөөд сэтгүүлийн нэрийг эзэмших эрх нь үүсгэн байгуулагчид хадгалагдана.

1.4.Сэтгүүл нь монгол хэлээр “Парламентын судалгаа шинжилгээ”, англи хэлээр “Research and Analysis” Journal of Parliament of Mongolia гэсэн оноосон нэрийг хэрэглэнэ.

1.5.Сэтгүүлийг эрхлэн гаргах үйл ажиллагааг Хүрээлэн хариуцна.

1.6.Сэтгүүл шуудангийн болон цахим хаягтай байна. Сэтгүүлийн шуудангийн албан ёсны хаяг нь Тамгын газрын хаяг байх бөгөөд цахим шуудангийн хаяг нь “journalpti@parliament.mn” байна.

**Хоёр.Нийтлэлийн бодлого**

2.1.Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлууд болон бодлого, эрх зүйн зохицуулалт шаардлагатай асуудлыг судлан шинжилж, шийдвэрлэх оновчтой хувилбарыг тодорхойлсон эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг эмхэтгэн хэвлүүлэхэд чиглэгдэнэ.

**Гурав.Сэтгүүлийн редакцын зөвлөл**

3.1.Сэтгүүл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй Сэтгүүлийн редакцын зөвлөл (цаашид “Редакцын зөвлөл” гэх)-тэй байна.

3.2.Редакцын зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэнэ. Редакцын зөвлөлийн дарга нь Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга байна.

3.3.Редакцын зөвлөлийн гишүүд нь судалгаа, шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд ажилласан туршлагатай, тодорхой салбаруудаар мэргэшсэн эрдэмтэн, судлаачид байна.

3.4.Сэтгүүлийн Ерөнхий редактор нь Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хариуцлагатай нарийн бичгийн дарга нь Хүрээлэнгийн сэтгүүл хариуцсан ажилтан байна.

3.5.Редакцын зөвлөлийн бүрэлдэхүүнийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар томилж, чөлөөлнө.

3.6.Редакцын зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгож болох бөгөөд урамшууллын хэмжээг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар тогтооно.

3.7.Редакцын зөвлөл дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ:

3.7.1.сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээл нь энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, уг бүтээлийг нийтлэх эсэх талаар дүгнэлт гаргах;

3.7.2.бүтээлд редакцын засвар хийх, эсхүл сайжруулах талаар зөвлөмж өгөх, шаардлагатай гэж үзвэл буцаах;

3.7.3.сэтгүүлийн нэр хүндийг өсгөх, цаашид үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц сэтгүүл болон хөгжихөд дэмжлэг үзүүлж, сэтгүүлийн чанарыг сайжруулахад анхаарч ажиллах;

3.7.4.сэтгүүлийн тухайн дугаарын сэдвийг тодорхойлох, өөрчлөх.

3.8.Ерөнхий редактор нь эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавин ажиллана.

3.9.Хариуцлагатай нарийн бичгийн дарга дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ:

3.9.1.сэтгүүл эрхлэн гаргах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.9.2.сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээл нь энэ журмын 4.4-т заасан нийтлэг шаардлагыг хангасан эсэхийг хянуулж, шаардлага хангаагүй бүтээлийг хүлээн авахаас татгалзах, засварлуулах, эсхүл зохиогчид буцааж сайжруулах ажлыг зохион байгуулах;

3.9.3.сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээлийг хүлээн авч Редакцын зөвлөлийн гишүүнээр хянуулахаар хүргүүлэх;

3.9.4.Редакцын зөвлөлийн гишүүний хянаж ирүүлсэн бүтээлийг шаардлагад нийцүүлэн засварлуулах, сайжруулах арга хэмжээ авах;

3.9.5.Редакцын зөвлөлийн хурал зохион байгуулах, тухайн дугаарыг эрхлэн гаргахтай холбоотой Зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг хэрэгжүүлэх.

### **Дөрөв.Сэтгүүлд нийтлэх бүтээлд тавигдах шаардлага**

4.1.Сэтгүүлд энэ журамд заасан нийтлэг болон тусгайлсан шаардлагыг хангасан, нийтлэлийн бодлогод нийцсэн бүтээлийг нийтэлнэ.

4.2.Сэтгүүлд нийтлэх бүтээл нь дараах төрөлтэй байж болно:

- 4.2.1.эрдэм шинжилгээний өгүүлэл;
- 4.2.2.судалгааны үр дүн, тойм;
- 4.2.3.дүн шинжилгээ;
- 4.2.4.шинжлэх ухааны тайлбар;
- 4.2.5.эсээ;
- 4.2.6.мэдээлэл;
- 4.2.7.ярилцлага;
- 4.2.8.шинэ бүтээлийн танилцуулга;
- 4.2.9.эх сурвалж, орчуулга.



4.3.Сэтгүүлд ирүүлсэн бүтээлийг сэдэв, агуулгаас нь хамааруулан тодорхой салбар, дэд сэдвүүдэд хувааж байршуулна.

4.4.Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээлд тавигдах нийтлэг шаардлага:

4.4.1.бүтээлийн нэр, зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй албан тушаал нь монгол, англи хэлээр байх;

4.4.2.бүтээлээ ирүүлэхдээ зураг (300dpi-аас доошгүй нягтаршилтай, .dri, .jpg, .psd өргөтгөлтэй), цахим шуудан, холбоо барих утасны дугаарыг хавсаргасан байх;

4.4.3.бүтээлийг MS Word программаар, үндсэн бичвэрийг Arial, 11pt, мөр хоорондын зай 1(single), эшлэл, зүүлтийг Arial, 10pt, мөр хоорондын зай 1(single) хэмжээтэй байхаар бичих бөгөөд .docx өргөтгөлөөр ирүүлэх;

4.4.4.бүтээл нь гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өмнө нь хэвлэн нийтлэгдээгүй байх;

4.4.5.зохиогчийн эрхийн зөрчилгүй байх;

4.4.6.эшлэл, зүүлтийг стандартын дагуу тэмдэглэсэн, зүй бус хэллэг ашиглаагүй байх.

4.5.Эрдэм шинжилгээний өгүүлэл:

4.5.1.Өгүүлэл дараах бүтэцтэй байна:

- а.гарчиг (монгол, англи хэлээр);
- б.түлхүүр үгс (монгол, англи хэлээр);
- в.хураангуй хэсэг (монгол, англи хэлээр);
- г.үндсэн хэсэг;
- д.дүгнэлт, санал зөвлөмж;
- е.эх сурвалж;
- ё.хавсралт.

4.5.2.Өгүүлэл нь гарчиг, түлхүүр үгс, товчлол, эх сурвалжийн жагсаалт, хавсралтаас гадна 2500-гаас доошгүй үгтэй байна.

4.5.3.Түлхүүр үгс нь 5 хүртэлх тооны холбоо үгээс бүрдэх ба бүтээлийн гарчигт ороогүй үгээс бүрдсэн байна.

4.5.4.Хураангуй (abstract) нь өгүүллийн агуулгыг ойлгомжтой байдлаар хураангуйлсан нэг цогцолбор байна. Хураангуй хэсэгт өгүүллийн аль нэг хэсгээс шууд хуулбарлаагүй байвал зохино.

4.5.5.Үндсэн хэсэгт бодлогын болон шинжлэх ухааны онол, арга зүйн дагуу боловсруулсан судалгааны үр дүн, кейс ашиглан дэвшүүлсэн санаагаа илэрхийлэх бөгөөд өөрийн биш санаа, өгүүлбэрт эшлэл авсан байна.

4.5.6.Дүгнэлт, саналыг бичихдээ Үндсэн хэсэгт дурдаагүй шинэ санаа оруулахгүй бөгөөд асуудлыг шийдвэрлэх арга замыг санал болгосон байна.

4.6.Судалгааны үр дүн, тойм:

4.6.1.судалгааны тойм нь цаг үеийн ач холбогдол бүхий аливаа судалгааны агуулга, үр дүнг тоймлосон байна.

4.6.2.судалгааны тойм нь 10-25 хүртэлх хуудастай байна.

4.7.Дүн шинжилгээ:

4.7.1.Бодлогын тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлж, оновчтой шийдлийг санал болгосон байна.

4.7.2.Дүн шинжилгээнд онолын болон бусад судлаачийн бүтээлийг ашигласан бол эшлэл, зүүлт авна.

4.8.Шинжлэх ухааны тайлбар:

4.8.1.Тайлбар нь эрх зүй, эдийн засаг, нийгэм зэрэг салбар шинжлэх ухааны тодорхой ойлголт, нэр томъёо, утга агуулгыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, нэг мөр ойлголт өгөхийг зорьсон байна.

4.8.2.Тайлбар нь 700-аас доошгүй үгтэй байна.

4.9.Эсээ:

4.9.1.Эсээ нь төрийн бодлогын аливаа асуудлыг үзэл бодол, чөлөөт сэтгэлгээний хүрээнд аливаа улс төржилтөөс ангид илэрхийлсэн бүтээл байна.

4.9.2.Зохиогч үзэл бодол, чөлөөт сэтгэлгээгээ илэрхийлэхдээ шинжлэх ухаанчаар хандаж, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, тоон мэдээлэл, эшлэл, зүүлтээр санаагаа бататгасан байвал зохино.

4.9.3.Эсээ нь 3000-аас дээшгүй үгтэй байна.


4.10.Мэдээлэл:

4.10.1.хууль тогтоох байгууллагаас гаргасан онцлох шийдвэр, хууль тогтоомж, цаг үеийн онцлох үйл явдлын тухай мэдээ болон бодлого судлалын салбарт шинээр гарсан бүтээл, эрдэмтэн, судлаачдын талаарх мэдээллийг нийтэлнэ.

#### 4.11.Ярилцлага:

4.11.1.Хууль тогтоогч, шийдвэр гаргагч, эрдэмтэн, судлаач, салбарын мэргэжилтнүүдтэй шинжлэх ухаан, хууль тогтоох байгууллагын хүрээний онцлох асуудлаар хийсэн байна.

4.11.2.Ярилцлага нь найруулга зүй, зөв бичих зүйн шаардлага хангасан, бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэсэн байна.



#### 4.12.Шинэ бүтээлийн танилцуулга:

4.12.1.Парламент судлал, үндсэн хууль судлал, бодлого судлалын салбарт шинээр хэвлэгдэн гарсан бүтээл, ном, гарын авлагын агуулга, ач холбогдлыг тоймлон танилцуулсан байна.

4.12.2.Танилцуулга нь хавтасны зураг бүхий 1 хуудаст багтсан байна.

#### 4.13.Эх сурвалж, орчуулга:

4.13.1.Тухайн мэдээллийн цаг үеийн болон эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлэх ач холбогдлыг нэн тэргүүнд харгалзан үзэж ховор, нэн шаардлагатай эх сурвалж, материалын орчуулгыг нийтэлж болно.

4.13.2.Сэтгүүлийн нэг дугаарт нэгээс илүүгүй эх сурвалж, орчуулгыг нийтлэх ба Редакцын зөвлөл эх сурвалж, орчуулгын үнэн зөв эсэхийг нягтлан, нийтлэхээс татгалзах эрхтэй.

4.13.3.Эх сурвалж, орчуулгыг ирүүлэхдээ эх материал хаана, хэзээ хэвлэгдсэнийг таньж болохуйц байдлаар хавсарган ирүүлнэ.

#### **Тав.Бүтээл хүлээн авах, хэвлэн нийтлэх, түгээх**

5.1.Сэтгүүлд бүтээл хүлээн авах зар түгээх, бүтээлийг хүлээн авах, эмхэтгэх, хэвлүүлэх, түгээх ажлыг тухайн чиг үүргийг хэрэгжүүлж буй Хүрээлэнгийн ажилтан хариуцна.

5.2.Сэтгүүлд бүтээл хүлээн авах зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах бөгөөд сэтгүүлийн хэвлэлийн эхийг бэлтгэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө олон нийтэд мэдээлнэ.

5.3.Бүтээлийг тухайн дугаар хэвлэгдэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авч Редакцын зөвлөлд хүргүүлнэ.

5.4.Редакцын зөвлөлөөс шаардлага хангаагүй гэж үзсэн бүтээлийг сэтгүүлд нийтлэхгүй байж болно. Энэ тухай зохиогчид мэдэгдэнэ.

5.5.Сэтгүүлийг жилд хоёр удаа Улсын Их Хурлын ээлжит чуулганы засварлагааны хугацаанд эмхэтгэн гаргана.

5.6.Шаардлагатай тохиолдолд сэтгүүлийн тусгай дугаарыг эрхлэн гаргаж болох бөгөөд ийнхүү гаргахдаа энэ журмын 5.2, 5.3 дахь хэсэгт заасан хугацааг

баримтлахгүй.

5.7.Сэтгүүлийг хэвлэж тараах хуваарийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар батлуулж мөрдөнө.

5.8.Сэтгүүлийн цахим хувилбарыг Хүрээлэнгийн цахим хуудсанд байршуулна.

5.9.Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн ашиглалт, оюуны өмчийн эрхийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаална.



---oOo---